



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/86

Цагаан-Уул сум

Г Г  
Хэсэгчилсэн хязгаарлалт тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4, 10.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 190 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай” 2024 оны 02 дугаар сарын 15-ний А/96 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2024 оны А/161 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын хэмжээнд бэлчээрийн хөнөөлт мэрэгч их хэмжээгээр тархсан Агар, Өвгөд, Тосон, Шарга, Хужирт багуудын өвөлжөө, хаваржааны бүс нутаг болох

- Агар багийн Зөөхий, Хөндлөн, Ямаат, Хөндий, Тээлийн дөрөлт, Буянт, Доод баянзүрх, Хар толгой, Өндөр цагаан толгой, Ухаа, Агарын гол, Тавт

- Өвгөд багийн Баян хөндий даваа, багийн төв, Далтын даваа, Оглогын гол, Шар мод, Цагаан-Уул

- Хужирт багийн Хужиртын эх, Хөх бэлчир, Салхит, Хүнх цахир, Цагаан гэлэн, Аваргын мухар, Уушиг, Евэн, Зураа, Хандийн толгой, Нарийн хөндий Халтирлаг, Хөшөөт

- Шарга багийн Баянхөндий, Хүрмэн, Мааньт, Нүхэн хад, Хуйт, Хар толгой, Нарийн хөндий, Дээд жаргалант зэрэг бэлчээрийн газруудад микробиологийн аргаар тэмцэх ажлыг зохион байгуулахтай холбогдуулж тухайн бүс нутагт 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг дуустал хэсэгчилсэн хязгаарлалт тогтоосугай.

2. Хязгаарлалт тогтоосон бүс нутагт мал оруулахгүй байх талаар мэдээллийг айл өрхүүдээр хүргэн хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Уг ажлыг зохион байгуулах явцад хүн, амьтан, мал сүрэг, байгальд учрах хор уршигийн нөлөөлөлд үнэлэлт дүгнэлт гарган, гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Г.Одгэрэл)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-т даалгасугай.

ДАРГА  С.ГОНЧИГНЯМ